



МОНГОЛЫН ШҮҮГЧДИЙН ХОЛБООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

Агуулга

Нэг. Бүтэц зохион байгуулалт, хүний нөөц бусад үйл ажиллагаа

- 1.1 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
- 1.1.2 Хяналтын Зөвлөлийн гишүүд
- 1.2 Ажлын алба

Хоёр. 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

- Нэг. 2.1 Дотоод зохион байгуулалтын чиглэлээр
- Хоёр. 2.2 Холбооны дүрмийн 3.1.2-т заасан чиглэлээр
- Гурав. 2.3 Холбооны дүрмийн 3.1.3-д заасан чиглэлээр
- Дөрөв. 2.4 Холбооны дүрмийн 3.1.4-д заасан чиглэлээр
- Тав. 2.5 Холбооны дүрмийн 3.1.5-д заасан чиглэлээр
- Зургаа. 2.6 Холбооны дүрмийн 3.1.7-д заасан чиглэлээр
- Долоо. 2.7 Холбооны дүрмийн 3.1.8-д заасан чиглэлээр
- Найм. 2.8 Холбооны дүрмийн 3.1.9-д заасан чиглэлээр

Гурав.

- 3.1 Бусад
- 3.2 Санхүү, татвар

1.1 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



Д.Батбаатар
Монголын Шүүгчдийн холбооны Тэргүүн,
УДШ-ийн шүүгч



Г.Ганбаатар
Удирдах зөвлөлийн гишүүн,
Нийслэлийн Эрүүгийн хэргийн
ДЗШШ-ийн шүүгч



Ц.Оч
Удирдах зөвлөлийн гишүүн,
Нийслэлийн Эрүүгийн хэргийн
ДЗШШ-ийн шүүгч



Л.Эрдэнэбат
Удирдах зөвлөлийн гишүүн,
Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний
хэргийн ДЗШШ-ийн шүүгч



Ц.Мөнхтулга

Удирдах зөвлөлийн гишүүн,
Нийслэлийн Эрүүгийн хэргийн
ДЗШШ-ийн шүүгч



З.Ганзориг

Удирдах зөвлөлийн гишүүн,
Нийслэлийн Захиргааны
хэргийн ДЗШШ-ийншүүгч



Н.Одонтуул
Ц.Эрдэнэчимэг

Удирдах зөвлөлийн гишүүн,
БЗД-ийн ЭХАШШ-ийн ерөнхий шүүгч



Удирдах зөвлөлийн гишүүн,
БГД-ийн ЭХАШШ-ийн шүүгч

1.1.2 Хяналтын Зөвлөлийн гишүүд



С. Отгонтуяа

Хяналтын зөвлөлийн гишүүн,
Дорноговь аймаг дахь захиргааны хэргийн
анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч



Д.Ганболд

Хяналтын зөвлөлийн гишүүн,
БЗД,СБД,ЧД-ийн ИХАШШ-ийн шүүгч



Ч.Мөнхцэцэг

Хяналтын зөвлөлийн гишүүн,
Нийслэлийн ИХДЗШШ-ийн шүүгч

1.2 Холбооны ажлын алба

Ажлын алба нь Монголын Шүүгчдийн холбооны өдөр тутмын үйл ажиллагааг хангаж, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

2025 оны ажлын албаны бүрэлдэхүүн:

- ✧ Гүйцэтгэх захирал: Т.Туяа
- ✧ Эрх зүйч, судлаач-гүйцэтгэх захирлын туслах ажилтан Э.Буянтогтох
- ✧ Нягтлан: Э.Тулгабаяр гэсэн бүрэлдэхүүнтэй ажилласан байна

2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

1.3 Дотоод зохион байгуулалтын чиглэлээр

Холбооны нийт гишүүдийн Их хурлыг товлон хуралдуулах, хэлэлцэх асуудлын тоймыг бэлтгэн танилцуулав.

ХӨТӨЛБӨР	
18:00-18:05	Их хурлын нээлт, хэлэлцэх асуудал, дарааллыг танилцуулах Д.Батбаатар, МШХ-ны тэргүүн
18:05-18:10	Мэндчилгээ Е.АМ төслийн зөвлөх, Нью Брансвик мужийн ерөнхий шүүгч Марк Ришард
18:10-18:20	Хураандаа даргалач болон нарийн бичгийн даргыг сонгох, хураанд аныг батлах МШХ-ны тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүд
18:20-18:30	Удирдах зөвлөлийн 2023-2025 оны үйл ажиллагааны төвч тайланг танилцуулах Д.Батбаатар, МШХ-ны тэргүүн
18:30-18:40	Хяналтын зөвлөлийн тайланг танилцуулах С.Отгонтуяа, МШХ-ны Хяналтын зөвлөлийн гишүүн
18:40-19:00	Асуулт, хариулт МШХ-ны тэргүүн, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүд
19:00-19:10	Шүүгчдийн холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг танилцуулах Д.Ганбаатар, МШХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн
19:10-19:30	Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналын хэлэлцүүлэг, батлах, тогтоол гаргах Хураандаа даргалач, нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн гишүүд
19:30-19:55	Гишүүний татварын хэмжээг өөрчлөх, батлах эсэх тухай саналыг танилцуулах Д.Батбаатар, МШХ-ны тэргүүн
19:55-20:00	Монголын Шүүгчдийн холбооны ээлжит их хурлын хаялт Хураандаа даргалач



Монголын Шүүгчдийн Холбооны ээлжит Их хурал 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Төрийн ордонд болж өнгөрлөө. Ээлжит Их хурлыг Монголын Шүүгчдийн Холбооны Тэргүүн, УД Ш - ийн шүүгч Д.Батбаатар даргалж, нарийн бичгийн даргаар Удирдах зөвлөлийн гишүүн Н.Одонтуулыг сонгов. Холбооны Их хуралд нийт гишүүдийн 61.3 хувь танхимаар оролцлоо. Их хурлаар Шүүгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн 2023-2025 оны үйл ажиллагааны тайлан, Хяналтын зөвлөлийн тайланг (QR) танилцуулж, хурлын дэгийг баталж, Шүүгчдийн Холбооны дүрэмд оруулах өөрчлөлт, гишүүнчлэлийн татвар нэмэгдүүлэх талаар хэлэлцэж, хэлэлцсэн асуудал тус бүрийг бүрэн шийдвэрлэв.




1.4 Дотоод зохион байгуулалтын чиглэлээр

Холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, төслийг, бэлдэж, Их хурлаар хэлэлцүүлж батлав.

2.1 Дотоод зохион байгуулалтын чиглэлээр

Ажлын алба нь Удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг тогтосон хугацаанд товлож, бэлтгэл ажлыг ханган, гаргасан тогтоолыг албажуулж, энэ тухай гишүүдэд мэдээлэх холбооны өдөр тутмын үйл ажиллагааг дүрэмд заасан үүрэг чиглэлийн дагуу явуулж, гишүүн шүүгчдэд мэдээлэл хүргэх ажлыг тухай бүр хийж байв.

Шүүгчдийн холбооны үйл ажиллагааны талаар гишүүн шүүгчдэд мэдээлэл хүргэх, шүүгчийн ажлыг иргэд олон нийтэд үнэн зөвөөр таниулан сурталчлах зорилгоор холбооны вэб сайт болон пэйж хуудсыг хөгжүүлж шүүх, шүүгчийн талаарх албан ёсны мэдээллийг гол эх сурвалж болгон байршуулж байна. Тайлант хугацаанд ажлын алба холбооны үйл ажиллагаатай холбогдуулан гүйцэтгэх захирлын 22 тушаал гаргаж, бусад байгууллагад хандсан 17 албан бичиг гаргасан байна.



❖ Төлөвлөгөөний 2.1-т: Шударга ёсны хэмжүүр сэтгүүл¹

Холбооны гишүүдийн эрдмийн болон чөлөөт уран бүтээлийг таниулах, сэтгүүлийг олон нийтэд хүргэх, Холбооны үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Шударга ёсны хэмжүүр” сэтгүүлийг жилд 2 удаа бэлтгэдэг. Тайлант хугацаанд


¹Шударга ёсны хэмжүүр сэтгүүл-

сэтгүүлийн ээлжит 32, 33 дахь дугаарыг бэлтгэн Шүүгчдийн холбооны сайтад цахим хэлбэрээр байршуулав.

Сэтгүүлийн 32 дахь дугаарт: МШХ-ны үйл ажиллагааны онцлох мэдээ мэдээлэл, салбар хороодоос тухайн шүүхийн Тамгын газартай хамтран хийсэн шүүх болон шүүгчийг олон нийт, иргэдэд таниулах, үйл ажиллагааг сурталчлах, эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох хүрээнд хийгдсэн мэдээ, Ярьж буй хууль нэвтрүүлэгт 2025 оны сүүлийн хагас жилд хийгдсэн нэвтрүүлэг тус бүрийн мэдээлэл эрх зүйн төрөл сэдвүүдийн танилцуулга мэдээлэл, “Өмчлөгчийн хариуцлага” сэдвээр явагдсан нэвтрүүлгийг ярилцлага хэлбэрээр буулгаж, “Иргэн, хуулийн этгээдийн шүүхэд хандах эрхийг захиргааны хэргийн шүүхээс хэрэгжүүлж буй байдал” Эрдэм шинжилгээний өгүүлэл зэргийг багтаасан.

Сэтгүүлийн 33 дахь дугаарт: Нийт шүүгчийн III чуулганы дэлгэрэнгүй мэдээлэл, МШХ Канадтай улсын шүүгчдийн холбоотой “Хамтран ажиллах санамж” бичиг байгуулсан талаар болон тус улсын засгын газрын шугамаар хэрэгжиж буй эхний жилийн ажлын төлөвлөгөөний талаар мэдээлэл зэргийг оруулан, санал солилцов.


Тус сэтгүүлийг холбооны сайтад /өнгөтөөр/ байршуулсан тул дэлгэрэнгүй үзэх, татаж авах боломжтой.



- **Төлөвлөгөөний 2.2-т: ШЕЗ-ийн “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлд “Монголын Шүүгчдийн Холбооны үйл явдлын хураангуй” нэрээр холбооны үйл ажиллагааг нийтлэх**


Холбооны үйл ажиллагааг өргөн хүрээнд таниулан сурталчлах, нийт шүүгчдэд хүргэх зорилгоор ШЕЗ-ийн “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлд “Монголын Шүүгчдийн Холбооны үйл явдлын хураангуй” нэрээр жилд 2 удаа үйл ажиллагаагаа танилцуулан байршуулдаг бөгөөд ² Холбооны үйл ажиллагааны 2025 онд хийгдсэн голлох ажлуудын хураангуйг бэлтгэн хүргүүлсэн байна.

² Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2025 он, Дугаар №- https://judcouncil.mn/site/news_full/14091



- **Төлөвлөгөөний 2.3-т Гишүүн шүүгчдийн гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, Фулбрайтын англи хэлний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.**

“Монголын Шүүгчдийн Холбоо” нь гишүүдийнхээ гадаад хэлний мэдлэгийг хөгжүүлэхийн тулд Шихихутуг Их Сургууль Монгол дахь АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран Фулбрайтын “Англи хэлний туслах багшийн хөтөлбөр” /Fulbright English Teaching Assistant (ETA) programm/-т хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна.



Хөтөлбөрийн хүрээнд 2020-2024 онд “Йэлийн их сургуулийг Түүх болон Зүүн Ази судлалын хос мэргэшлээр төгссөн, АНУ-ын иргэн (native speaker) Maya Albold 2024 оны 9 сарын 1-нээс эхлэн 2025 оны 6 сар хүртэл Шүүгчдийн Холбооны хүсэлт гаргасан гишүүн шүүгч нарт англи хэл сургалтыг амжилттай явуулав. Тус сургалтад танхимаар 42 шүүгч, цахим хэлбрээр 24 шүүгч, нийт 65 шүүгч бүртгүүлж суралцсан байна.

Сургалтын хаалтын ажиллагаа буюу сертификат гардуулах үйл ажиллагаа 2025 оны 5 дугаар сарын 18-ны өдөр болж АНУ-ын Элчин сайдын яам, Монголын шүүгчдийн холбоо, Шихихутуг их сургуулийн төлөөлөл оролцов.



Уг сургалтын 2025-2026 оны хичээлийн жилийн “Англи хэлний туслах багшийн хөтөлбөр”-т сургалт явуулах болзол шаардлагыг хангасан Вашингтон ДС мужийн Американ их сургуулийг 2020-2024 онд “Олон улс судлалын мэргэшлээр” төгссөн, АНУ-ын иргэн (native speaker) Эмили Хуйзи Брайланд нь гишүүн шүүгч нарт англи хэлний сургалт үргэлжлүүлэн явуулж байна.

➤ **Төлөвлөгөөний 2.4-т Judicial Wellbeing буюу Шүүгчийн ажил мэргэжлийн зохист хэвшлийн талаар сургалт зохион байгуулав**

Монголын шүүгчдийн холбоо, Шүүхийн академитай хамтран шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлийн Judicial Wellbeing-шүүгч-сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг зарласанаар “Шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэнд” сэдэвт 2 шатны сургалт явагдав. Сургалтад хүсэлт гаргасан 10 шүүгч оролцож. Австрали улсаас хуульч, эмпирик сэтгэл судлаач, доктор Карли Шревер, сэтгэл судлаач, гэр бүлийн сэтгэл засалч, Human Ethos байгууллагын захирал Салли Райан нар хүрэлцэн ирж сургагч багшаар бэлтгэгдэж буй 10 шүүгчид сургалтыг амжилттай зохион байгуулав.





Энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан “шүүгчийн стресс болон ажлаас халшрах хам шинж”- ийг үүсгэж буй хүчин зүйлсийг хэрхэн даван туулах, сэтгэл зүйн хувьд үүсэх сөрөг хүчин зүйлийг тодорхойлж, асуудлыг зөв аргаар хэрхэн шийдвэрлэж сэтгэл зүй болон бие махбодыг хэвийн тогтвортой байлгах, өөрийнхөө сэтгэл зүйг удирдан чиглүүлэх аргыг шүүгч нарт төлөвшүүлэхээр үе шаттайгаар сургалт зохион байгуулагдахаар төлөвлөгдөж байна.

Шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэнд онцлох, анхаарал тавих асуудал

Шүүгчдийн холбоо нь гишүүддээ үйлчлэх ТББ болохын хувьд шүүгч нарын сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дээшлүүлэх урт хугацааны сургалт, заслын хөтөлбөрийн эхлэлийг тавив.

Монголын Шүүгчдийн холбооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус холбоо нь Шүүхийн академи, Монголын Шүүгчдийн холбооны Улсын дээд шүүх дэх салбар зөвлөл, Улсын дээд шүүхийн Тамгын газартай хамтран шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлийн шүүгч-сургагч багш бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд “Шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэнд сэтгэл зүйд суурилсан манлайлал ба хамт олны харилцаа” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.



Сургалтын хүрээнд шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн чиг хандлага, олон улсын судалгаатай танилцаж, стресс үүсгэгч болон хамгаалагч хүчин зүйлс, стрессийн хариу урвалын нөлөөллийг ойлгон, урьдчилан сэргийлэх аргуудтай танилцах, түүнчлэн стресс, ажлаас халшрах хам шинжээс сэргийлэх, сэтгэл зүйн асуудлуудыг ялган таних, стрессийг удирдах, бие махбод, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг дэмжих арга замуудыг судалсан юм.

Мөн сэтгэл зүйн эрүүл мэндийн хувийн төлөвлөгөө боловсруулах, шүүхүүд хэрхэн сэтгэл зүйн эрүүл мэндтэй холбоотой соёлыг дэмжиж хөгжүүлэх Монголын нөхцөлд сайн туршлагыг хэрхэн нутагшуулах талаар харилцан яриа өрнүүлэн, туршлага солилцсон.Хоёр өдрийн турш үргэлжилсэн сургалтыг Австрали улсын тэргүүлэх мэргэжилтэн, судлаач Карли Шревер, сэтгэл судлаач, гэр бүлийн сэтгэл засалч Салли Райан нар удирдан явуулсан. Энэхүү хоёр мэргэжилтэн нь уг сэдвээр тэргүүлэх мэргэжилтнүүд бөгөөд өндөр хөгжилтэй улс орнуудын шүүгч нарт энэ сэдвээр сургалт явуулсан туршлагатай. Тэднийг урьж сургалт авах боломжийг олгосон Шүүхийн академийн захирал, УДШ-ийн Тамгын газрын дарга нарт болон сургалтын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хариуцаж ажилласан Г.Халиунаа, Б.Аззаяа зэрэг ажилтнуудад сургагч багш болон цаашид сургалтын үр шимийг хүртэх нийт гишүүдийн өмнөөс талархаж байна.

Энэхүү сургалтад холбооны гишүүн 10 шүүгч хамрагдсан. Сургалтдаа идэвхтэй хамрагдсан, хариуцлагатай шүүгч-гишүүддээ баярлалаа. Цаашид энэхүү сургагч-багш нарыг үргэлжлүүлэн сургахад дэмжих, сургагч-багш нар өөрсдөө бие даан суралцаж мэргэших, сургалтын гарын авлага бэлтгэх замаар МШХолбооны шүүгч-гишүүн бүрд өөрийнх нь ажил, мэргэжлээс үүдэлтэй стресс, сэтгэл зүйн мэдлэг, ур чадварыг таниулах “шүүхийн сэтгэл зүйн сайн сайхан байдлын” сургалтыг хүргэхэд зорьж байна.

Мөн МШХолбоо энэ хүрээнд Канадын Засгийн газрын хэрэгжүүлэх гэж буй төсөлтэй хамтран ажиллах санал хүргүүлсэн. Шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн талаар цаашид шүүгч, шүүх, шүүхийн системд гэсэн 3 түвшинд ямар бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэх, сургалт, гарын авлага, журам боловсруулах зэрэг хэрэгцээ, шаардлага бий.

➤ **Төлөвлөгөөний 2.5-т Шихихутуг Их сургуультай хамтран ажиллах санамж бичиг, гэрээний дагуух үйл ажиллагааг үргэлжлүүлэх**

Шүүгчдийн холбоон болон Шихихутуг Их Сургуультай хийсэн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хийсэн гэрээнд тусгагдсан заалтын дагуу хамтын ажиллагаа үргэлжилсээр байна. 2023 оноос хэрэгжиж эхэлсэн “Mentor Ship” хөтөлбөрийн хүрээнд Эрүү, Иргэн, Захиргааны эрх зүйн процессын болон Жууль хэрэглээний хичээлийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч багш нар Шихихутуг Их Сургуулийн оюутнуудад тогтсон цагаар хичээл зааж дадлагын оюутнуудыг тухайн шүүгч нарт хуваарилан шүүхийн үйл ажиллагаатай танилцуулж дадлагажууллаа. Мөн Их дээд сургуульд багшлах эрхийн чадамж олгох сургалтанд 2 ээлжээр 46 шүүгчийг хамруулж 18 шүүгч багшлах эрхийн үнэмлэхээ гардан авч, 2-р ээлжийн 18 шүүгч энэхүү сургалтад нь хамрагдаад байна.

□ **Төлөвлөгөөний 2.6-т Эрх зүйн онолын болоод салбарын сүүлийн үеийн шинэлэг ойлголт, тодорхой судлаачийн судалгааны ажлын талаар хэлэлцүүлэг, яриаг өрнүүлэх**



“Шүүх хуралдаан хойшлогдож буй нийтлэг шалтгаан,шийдвэрлэх зарим боломж” “bench&bar” Уулзалтыг анх удаа зохион байгууллаа.

Улсын дээд шүүхийн байранд 2025 оны 11 дүгээр сарын 27- ны өдөр “Шүүх хуралдаан хойшлогдож буй нийтлэг шалтгаан, шийдвэрлэх зарим боломж” чөлөөт уулзалтыг Монголын Шүүгчдийн Холбоо санаачлан, Монголын Өмгөөлөгчдийн Холбоотой хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээний зохион байгуулагчаар “Judilogy” төслийн баг, “Шүүхийн академи” хамтран ажиллав. Уулзалтын онцлог нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид болох шүүгч болон үйлчлүүлэгчийн эрх ашгийг төлөөлөх мэргэжлийн этгээд болох өмгөөлөгчийн хооронд шүүхийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэг хянан шийдвэрлэх процесс, мэргэжлийн ёс зүй зэрэг нийтлэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж, хамтын ажиллагаанд суурилан асуудал тодорхойлж, шийдвэрлэх арга замыг хэлэлцэн зөвлөлддөг онцлогтой. Уулзалтыг нээж Монголын Шүүгчдийн Холбооны Тэргүүн, Улсын дээд шүүхийн шүүгч Д.Батбаатар , Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч Л.Данзанноров нар үг хэллээ. Уулзалтын үеэр Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Судалгааны төвийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга Б.Дөлгөөн шүүх хуралдаан хойшлогдож буй шалтгаан, хүсэлт гаргаж буй субъект, хугацаа, давтамжийн статистик мэдээллийг 13 шүүхийн статистикт үндэслэн шүүх хуралдаан хойшлуулж буй нийтлэг шалтгааныг судалгааны үр дүнгээр гаргаж, шүүх хуралдаан хойшилсон дэлгэрэнгүй статистик мэдээллийг танилцууллаа. Шүүгчид болон өмгөөлөгчид шүүх хуралдаан хойшлогдоход нөлөөлдөг хүчин зүйлсийн талаар нээлттэй санал солилцож оролцогчид, өөр өөрсдийн зүгээс анхаарах шийдвэрлэх гарцыг эрэлхийлсэн чөлөөтэйсанал бодлоо илэрхийлсэн сонирхолтой уулзалт боллоо. Уулзалтад нийслэл, дүүрэг, орон нутгийн анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн төлөөлөл, Өмгөөлөгчдийн Холбооны өмгөөлөгчид идэвхтэй оролцлоо. Уулзалтын төгсөлд Шүүгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч З.Ганзориг тус уулзалтын талаар саналаа дүгнэж хэлэв.



Гурав. 2.3 Холбооны дүрмийн 3.1.3-д заасан чиглэлээр³

- Төлөвлөгөөний 3.1-т Үндсэн хуулийн хүрээлэнгээс эхлэн гаргасан “Үндсэн хууль манайд сургуульд” хөтөлбөрийг ашиглан шүүгч нараар иргэд, олон нийтэд ардчилал, хүний эрхийн талаар яриа, таниулгыг өргөн хүрээнд зохион байгуулах

МШХ нь Салбар хороод болон, гишүүдээс ирүүлсэн саналын үндсэн дээр баталсан 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.1-д Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгээс эрхлэн гаргасан “Үндсэн хууль манай сургуульд” хөтөлбөрийг ашиглан шүүгч нараар иргэд, олон нийтэд ардчилал, хүний эрхийн талаар яриа

³ 3.1.3. Шүүхийн бие даасан, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, хэвлэл мэдээллийн хурал зохион байгуулах

таниулгыг өргөн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний хүрээнд тус холбооны удирдах зөвлөлийн гишүүн, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Мөнхтулга 2025 оны 03 дугаар сард “Шинэ Монгол Харүмафүжи” ЕБС-ийн ахлах ангийн 300 гаруй сурагчдад төрийн эрх мэдэл хуваарилах онолын хүрээнд Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг хэрхэн тусгасан, шүүхийн тогтолцоо, шүүгч болох болзол шаардлага, мэргэжлийн онцлог, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, шүүгч хүний өдөр тутмын ажлын хуваарь болон эрүүгийн гэмт хэрэг, зөрчлийн ялгаа, хор уршиг түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сургалт явуулж, сурагчдын сонирхсон асуултад хариуллаа.



□ **Төлөвлөгөөний 3.2-т “Шинэ үе нээлттэй шүүх” төслийг үргэжлүүлэх**

“Нээлттэй шүүх” өдөрлөг НЭХДЗШШ-д Шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох зорилго бүхий “Нээлттэй шүүх” өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Ерөнхий боловсролын “Шинэ Монгол Харүмафүжи” сургуулийн “Зөв гурвалжин” мэтгэлцээний клубийн сурагчид хамруулж тус шүүхийн үйл ажиллагаатай танилцуулав.



Сурагчидыг тус шүүхийн Ерөнхий шүүгч Б.Зориг, Шүүгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн шүүгч Г.Ганбаатар, Ц. Оч нар хүлээн авч Шүүх эрх мэдэл, шүүгчийн ажил мэргэжлийн онцлогийн талаар мэдээлэл өгч сурагчдын сонирхсон асуултад хариулав.



□ **“Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг хамтдаа” Сургалт зохион байгуулав**



2025 оны 11 дүгээр сард Гэр бүл, хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Чингэлтэй дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэстэй хамтран “Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг хамтдаа” сургалт, өдөрлөгт тус холбоонб удирдах зөвлөлийн гишүүн НЭДЗШШ-ийн шүүгч Ц.Мөнхтулга оролцож, Нийслэлийн ерөнхий боловсролын 23-р сургуулийн ахлах ангийн сурагчидад “Үе тэнгийн дээрэлхэлтээс өөрийгөө хэрхэн хамгаалах вэ” Эрүүгийн гэмт хэрэг зөрчлийн ялгаа, хор уршиг түүнээс хэрхэн урьдчилан түүнээс сэргийлэх талаар сургалт явуулж сурагчдын сонирхсон асуултанд хариулав.



**Дөрөв. Холбооны дүрмийн 3.1.4-д заасан чиглэлээр⁴
Төлөвлөгөөний 4.1-т Олон Улсын Шүүгчдийн Холбооны Ази, Номхон
далай, Хойд Америкийн бүсийн уулзалт болж
Монголын шүүгчдийн холбооны төлөөлөл оролцлоо**

2025 оны 5 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Канад Улсын Торонто хотод зохион байгуулагдсан Asian, North American and Oceanian Judges' Associations (ANAO)-ийн жилийн явцын (Mid Year Meeting)-д уулзалт, хэлэлцүүлэгт Монголын Шүүгчдийн Холбооны төлөөлөл амжилттай оролцож, түншлэл, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх урьдчилсан алхам хийлээ. Тус уулзалтад Канадын Холбооны Шүүхийн Шүүгчийн Холбоо, АНУ-ын Холбооны Шүүгчдийн Холбоо (USA Federal Judges Association), Казахстаны Шүүгчдийн Холбоо (Union of Judges of the Republic of Kazakhstan), Шинэ Зеландын Шүүгчдийн Холбоо (Judges Association of New Zealand), Австралийн Шүүгчдийн Холбоо (Australian Judicial Officers Association), Тайваний Шүүгчдийн Холбоо (Judges Association of the Republic of China/Taiwan) зэрэг байгууллагуудын төлөөлөгчид оролцов.

Монголын Шүүгчдийн Холбооны төлөөлөл, гадаад харилцааны хорооноос Ц.Цогт (холбоонд төлөөлөгч оролцуулах зардал байхгүй тул өөр эх үүсвэрээр оролцсон) хэлэлцүүлэгт оролцож, Монгол Улсад шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй шинэчлэл, хууль эрх зүйн орчны сайжруулалт, олон нийттэй харилцах бодлого зэргийг товч танилцуулсан байна.

**“Хамтран ажиллах санамж” бичиг байгуулж, эхний жилийн ажлын
төлөвлөгөөний талаар санал солилцов.**



Канад Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газар (КУХШХЭГ) болон Монголын шүүгчдийн холбооны хооронд “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” (EJAM) төслийн хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр “Хамтран ажиллах санамж” бичиг байгууллаа. Шүүхийн хараат бус байдал, шүүгчийн ёс зүй, жендэрийн стратеги, шүүхийн ил тод, нээлттэй байдал, олон нийтийн хүртээмжийг сайжруулж, нэмэгдүүлэхэд чиглэсэн, 2030 он хүртэл хэрэгжих уг төслийн хүрээнд Монголын шүүгчдийн холбооноос хэрэгжүүлж буй үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэхэд КУХШХЭГ-аас дэмжлэг үзүүлэх, олон улсын тэргүүлэх туршлагаар хангах, хүний нөөцийг чадавхижуулах, техникийн мэдлэг туршлагыг бэхжүүлэх, хамтарсан сургалт, туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг олон чухал үйл ажиллагааг “жендэрийн тэгш байдал, хүний эрх, ил тод байдлын зарчим”-ыг удирдлага болгон хэрэгжүүлэх юм. Төслийг хамтран хэрэгжүүлэгч

⁴ 3.1.4. Гадаад, дотоодын ижил зорилго бүхий байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллах, шүүгчдийн сургалт, айлчлалыг харилцан зохион байгуулах, түүнчлэн шүүгчид дээрх байдлаар харилцаа тогтоох, харилцан мэдээлэл туршлага солилцох, хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;

талууд 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр уулзаж, төслийн эхний жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны зохион байгуулалтын талаар харилцан санал солилцов. Уг уулзалтад Монголын шүүгчдийн холбоог төлөөлж Тэргүүн Д.Батбаатар, Удирдах зөвлөлийн гишүүн Л.Эрдэнэбат, Ц.Мөнхтулга, З.Ганзориг нар оролцлоо.

Олон улсын шүүгчдийн холбооны 67 дугаар их хуралд МШХ-ны төлөөлөгчид оролцлоо.



Олон улсын шүүгчдийн холбооны 67 дугаар Их хурал 2025 оны 10 дугаар сарын 11-17-ны өдрийн хооронд Азербайжан улсын нийслэл Баку хотод болж, 71 гишүүн улсын төлөөлөл чуулсан. Монголын Шүүгчдийн Холбоог төлөөлж Тэргүүн Д.Батбаатар, гадаад харилцааны хорооноос Ц.Цогт (холбоонд төлөөлөгч оролцуулах зардал байхгүй тул өөр эх үүсвэрээр), Удирдах зөвлөлийн гишүүн З.Ганзориг (хувийн зардлаар) нар оролцлоо. Олон улсын шүүгчдийн холбооны Их хурал нь Бүс нутаг /Европ, Өмнөд Америк, Африк болон Ази, Хойд Америк, Номхон далайн орнууд/-ийн холбоодын хуралдаан, Төв зөвлөлийн хуралдаан, Судалгаа /шүүх, эрүү, иргэн, нийтийн эрх зүй/-ны комиссын хуралдаанаас бүрддэг. Ази, Хойд Америк, Номхон далайн орнуудын бүс (АНАО)-ийн хуралдаанд Монгол Улсаас гадна Канад, Австрали, Шинэ Зеланд, Бермуда, Казакстан, Америкийн Нэгдсэн улсын шүүгчдийн холбооны төлөөллүүд биечлэн оролцож, өнгөрсөн хугацаанд тус тусын холбоодын



хэрэгжүүлсэн онцлох үйл ажиллагааны талаар танилцуулж, тулгамдаж буй асуудлаар санал солилцсон. Тухайлбал, шүүхийн бие даасан байдал, шүүгчийн сэтгэлзүй, ажлын ачаалал, эрүүл мэндийн асуудал хийгээд бүх нийтийн боловсрол олгоход шүүгчийн оролцоо чухал зэргийг хэлэлцэж, Төв зөвлөлийн нэгдсэн санал дүгнэлтэд тусгуулахаар зэрэгцээ АНАО бүсийн уулзалтын давтамжийг ойртуулах, дараагийн уулзалтын зохион байгуулалтын асуудал болон БНСУ, Сингапур, Пакистан, Энэтхэг, Вьетнам зэрэг тивийн зарим улсыг цаашид гишүүнээр элсүүлэх боломжийн талаар харилцан ярилцав. МШХ-ны Тэргүүн Д.Батбаатар Шинэ Зеланд улсын Шүүгчдийн холбооны Тэргүүн Noel Sainsbury нар Монголын шүүгчдийн холбооны хувьд бүс нутгийн улсын Шүүгчдийн холбоодтой хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд Америкийн Нэгдсэн Улс, Шинэ Зеланд улсын Шүүгчдийн холбоотой 2025 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав. Гишүүддээ үйлчилдэг холбоодын хувьд харилцан туршлага солилцохоос гадна манай гишүүн-шүүгчдийн хувьд, англи хэлийг орчинд нь суралцах боломжийг

эрэлхийлэхэд хоёр улсын шүүгчдийн холбооны хамтын ажиллагаа чиглэх юм. Дээрх агуулгаар хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах саналыг Канад, Австрали улсуудын холбоод найрсагаар хүлээн авч, хариу өгөхөө илэрхийлсэн болно. Монголын шүүгчдийн холбооны төлөөлөгчдийн хувьд I судалгааны комиссын хуралдаанд оролцсон бөгөөд тус комиссын тайлан дүгнэлтэд тусгуулах саналаа МШХ-ноос урьдчилан хүргүүлсэн. ОУШХ-ны 68 дугаар Их хурал 2026.10.15-21-ний хооронд Португаль улсад болно.



- **Төлөвлөгөөний 4.2-т “Япон, /Солонгос/ болон гадаадын шүүх, эрх зүйн боловсролын тогтолцоотой танилцах аялалыг зохион байгуулах**

2025 оны байдлаар 2023 онд бүртгэгдсэн нэрсийн жагсаалтаар 13 шүүгчийг Японы аялалд бүртгэж нэрсийг баталгаажуулан, бэлтгэл ажил хангагдсан. 2026 онд явахаар төлөвлөгдсөн.

- **Төлөвлөгөөний 4.4-т Жой Спурлок сантай хэрэгжүүлж буй хамтын ажиллагааг үргэлжлүүлэх**

JOE SPURIOCK сангийн төлөөлөгчдийг Монголд 2025 оны 5 сард Улаанбаатар хот болон хөвсгөл аймагт хүлээн авч сургалт зохион байгуулав.



Мужийн шүүгч болоод албаны хүмүүс шүүхийн үйл ажиллагаатай танилцаж байна

- Сургалтын удирдамжид заагдсан сэдвийн хүрээнд АНУ-ын Тэхас мужийн шүүгч ноён Мэтью, JOE SPURIOCK сангийн удирдах зөвлөлийн гишүүн ноён Ганзориг нар

1. АНУ-ын мужуудын шүүхийн бүтэц тогтолцоо,
2. АНУ-ын шүүхийн шүүгч нарын ёс зүй дүрэм журам,
3. Шүүхийн захиргааны ажилчдын ёс зүй,
4. Дагнасан шүүхийн үйл ажиллагааны хэлбэр бүтэц тогтолцоо /Гэр бүл, авлига, татвар/ гэх мэт

Мөн сургалтын явцад хэлэлцүүлэг өрнүүлж, оролцогчдын сонирхсон асуултад хариулт өгч, нээлттэй ярилцаж сургалт үр дүнтэй болжээ.

Тав. Салбар хороодруу чиглэсэн ажил

- Төлөвлөгөөний 5.1-т Шүүхийн цахимжилттай холбоотой шүүгч нарт чиглэсэн сургалт зохион байгуулах

Монголын шүүгчдийн холбооны Ээлжит их хурлаар Салбар хороодод чиглэсэн дүрмийн нэмэлт өөрчлөлт оруулж дүрмийн 8,2-т шүүн таслах ажиллагааны дагнасан төрөл, байршил, нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу байгуулагдсан Нийслэл дэх шүүх бүр салбар хороодтой байна гэж нэмэлт өөрчлөлт оруулсаны дагуу зарим аймаг, нийслэл дэх анхан болон давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч нарт салбар хороог шинээр байгуулж тэргүүний сонгох талаар албан бичиг хүргүүлэв. Өөрчлөлт ороогүй салбар хороодыг шинээр байгуулах шаардлагагүй болон шинээр байгуулагдсан салбар хороод тэргүүн нарыг бүртгэж баталгаажуулав. Шүүхийн тухай хууль болон ШХ дүрэмд өөрчлөлт орсноор Салбар хороодтой болсон байна.

➤ Төлөвлөгөөний 6.1-т Ярьж буй хууль нэвтрүүлгийг үргэлжлүүлэх

Шүүгчдийн холбоо нь шүүхийн үйл ажиллагаа, шүүгчдийн ажил, үүргийг олон нийтэд таниулах, иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор хүргэж буй “Ярьж буй хууль” теле нэвтрүүлгийг 5 дугаарыг нэмж бэлтгэн 59,60,61,62,63 дугаарын нэвтрүүлгийг дугаарын нэвтрүүлгийг цахим сайтууд болон “ТВ-9”, “Соён гэгээрүүлэх” зэрэг телевиз болон шүүхийн ерөнхий зөвлөлийн сайтад байрлуулж хөтөлбөрийн дагуу олон нийтэд хүргэв. Түүнчлэн өмнөх жилийн бэлтгэж бичлэг хийгдсэн Дугаарыг эфирт цацсан байна.

МОНГОЛЫН ШҮҮГЧДИЙН ХОЛБОО

ЯРЬЖ БУЙ ХУУЛЬ



№54

Сэдэв: “ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ”

Шүүгч: НАДАЙХ ДҮҮРГИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ ХАСБАТАЙН БАБОЛД

Зочин: ТВ9 ТЕЛЕВИЗИЙН МЭДЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА СЭТГҮҮЛЧ ХАНАРАНЗЭРЭЛ

№55

Сэдэв: “НОТАРИАТЫН МЭДЭГДЭХ ХУУДАС”

Шүүгч: ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧ ЦОЮУНИЛЭЛ

Зочин: МУСГА, СЭТГҮҮЛЧ ГЭЭЛЖАРГАЛ

№56

Сэдэв: “БЭЛГЭЛЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ЗАРИМ АСУУДАЛ”

Шүүгч: БУЛГАН АЙМГИЙН ЭРҮҮ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧ ЛАРИУНЦЭЦЭГ

Зочин: ШУТИС-ИЙН БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ХУМУУНЧЛЭГИЙН СУРГУУЛИЙН ТӨРИЙН УДИРДЛАГА ХӨТӨЛБӨРИЙН АХЛАХ БАГШ ХУЛЬ ЗҮЙН МАГИСТР Т.НЯМДУЛАМ

№57

Сэдэв: “ШҮҮХЭД МЭДҮҮЛЭХ ИРГЭНИЙ ЭРХ”

Шүүгч: ТӨВ АЙМАГ ДАХЬ ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧ Д.МӨНХБҮРЭН

Зочин: СУДЛААН Л.ГАЛБААТАР

№58

Сэдэв: “ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС СЭТГЭЦЭД УЧИРСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ”

Шүүгч: СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧ ГОЧООГИЙН НЯМСҮРЭН

Зочин: СЭТГҮҮЛЧ ЖАНХБАЯР



Сэдэв: "МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ"

Шүүгч: НИЙСЛЭЛИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧ ЦАЛТАНЦЭЦЭГ

Зочин: ХИЛИЙН ЦЭРГИЙН ДУУ БУЖГИЙН ЧУУЛГЫН ДУУЧИН ЛУРАНБОЛОР



Сэдэв: "ТУСГАЙЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ"

Шүүгч: ДҮҮРГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХЯЛБАР АЖИЛЛАГААНЫ АНХАН ШАТНЫ ТОЙРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧ ЭДӨЛГӨРМАА

Зочин: ГЛАНБААР



Сэдэв: "ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ"

Шүүгч: БАЯНГОЛ, ХАН-УУЛ, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ТОЙРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧ Т.АРИУНБОЛД

Зочин: ХҮМҮҮНЛЭГИЙН ИХ СУРГУУЛИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙН ТЭНХИМИЙН БАГШ, (PH.D), ДЭД ПРОФЕССОР Л.АРИУН



Сэдэв: "УЛСЫН БҮРТГЭЛ ҮНЭН ЗӨВ БАЙХ ЗАРЧИМ"

Шүүгч: НИЙСЛЭЛ ДЭХЬ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧ Д.ХАЛИУНА

Зочин: ХУУЛЬЧ Б.ПҮРЭВСҮРЭН

Долоо. Холбооны дүрмийн 3.1.8-д заасан чиглэлээр⁵

- Төлөвлөгөөний 8.1-т Шүүгчийн эрүүл мэнд, нийгэм хамгааллын асуудлыг анхаарч, эмнэлгийн багц үзлэг шинжилгээнд хамруулах

Шүүгчдийн холбооноос шүүгч гишүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж Улсын хоёрдугаар төв эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээг байгуулав. Уг гэрээний дагуу 37 салбар хороодоос ирүүлсэн бүртгэлийг үндэслэн 2025 оны 04-р сарын 10-аас 2025 оны 05 сарын 02 өдрүүдэд УХТЭ-ийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд нийт 100 гаруй шүүгч нар хамрагдахаар хүсэлтээ өгснөөс 75 шүүгч үзлэгт хамрагдсан байна.

Хүйсийн ангилалаар :

- ✓ Эрэгтэй 17
- ✓ Эмэгтэй 58


Шүүгчдийн холбооны зүгээс шүүгчдийн эрүүл мэндийн байдалд анхаарч урьдчилан сэргийлэх үзлэгийг салбар хороод болон шүүгчдээс ирүүлсэн саналыг үндэслэн жил бүр зохион байгуулж буй бөгөөд үзлэгт хамрагдахаар хүсэлт гаргасан шүүгч нарыг нэгдсэн журмаар үзлэгт хамруулж оочир дугааргүй үзүүлэх цаг хэмнэх давуу талтай юм.

⁵ 3.1.8. Гишүүддээ сэтгэл санааны болон эд материалын туслалцаа үзүүлэх;


Нийт өвчлөлийг графикаар харуулсан байдал



Хеликобактери халдвар



Витамин Д дутагдал



Эрүүл мэндийн үзлэг шинжилгээний дагуу УХТЭ-ийн өгсөн зөвлөмж:

Үзлэгээр ажиллагсдын дунд тохиолдож буй өвчнийг эрт, илрүүлэн, оношлож, хүндрэлээс сэргийлэх цаашид эрүүл мэндийг хэрхэн хянах, эрүүлжүүлэх ажлын талаар дараах заавар зөвлөмжүүдийг өгч байна.

- ✓ Эрүүл мэндийг дэмжих хамгаалах, эрүүлжүүлэх арга хэмжээг жил бүрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх
- ✓ Ажилчдын эрүүл мэндийн картанд эмчилгээ зөвөлгөөг хүн тус бүрт өгч бичсэн байгаа.
- ✓ Ажилчдын эрүүл мэндийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
- ✓ Эрүүл хооллолтын хэв маягийг хэвшүүлэх: ажлын хоолны газар нь амьтны гаралтай өөх тос, транс тос болон хэт шарж түлсэн хоолноос татгалзах, амтлагч халуун ногоо, хэт их давстай болон хоносон удаан хадгалсан хоол хүнс хэрэглэхгүй байх тал дээр анхаарах,
- ✓ Архи, тамхины хэрэглээг бууруулах тал дээр уриалан чиглүүлэх
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдалыг хангаж, анхааран, зөвлөмжүүдийг өгөх
- ✓ Нийтийн биеийн тамирын дасгал, идэвхтэй хөдөлгөөн, спортын уралдаан тэмцээнд оролцуулан чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэвшүүлэх, дадал суулгах, орчин нөхцөлөөр хангах
- ✓ Цусан дахь холестерин хэмжээ ихсэх нь зүрх судасны өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг төдийгүй дэлхийд жил бүр 4 сая хүний гэнэтийн үхлийн шалтгаан болж байдаг. Нийт ажилчдын 26% цусан дахь холестерин хэмжээ их гарсан байна. Иймд амьдралын хэв маягийг өөрчилөх тал дээр анхааран ажиллах.

Үүнд: Давсны хэрэглээг бууруулах, жимс, хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх, амьтны гаралтай өөх тосны хэрэглээг бууруулах, биеийн жингээ хэвийн хэмжээнд барих.

Урьдчилан сэргийлэх үзлэг нь нэгдсэн журмаар явагдаж тухайн эмнэлгийн зүгээс амралтын өдрөөр эмч эмнэлгийн зүгээс зөвхөн хамтын ажиллагааны хүрээнд шүүгчдийг хүлээн авч тухайн үзлэг шинжилгээг хийж шүүгчдийн цаг хугацааг хэмнэсэн. Эмнэлгээс ирүүлсэн зөвлөмжийг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн.

- Төлөвлөгөөний 8.3, 8.4-т Холбооны гишүүн-шүүгч нарт тусламж, дэмжлэг үзүүлэх журамын 2.1-д заасны дагуу

Шүүгчдийн холбооны Удирдах зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 17-ны 08 дугаар тогтоолоор баталсан Шүүгчдийн холбооны гишүүн шүүгч нарт тусламж, дэмжлэг үзүүлэх журмын 2.1 дэх хэсэгт зааснаар 2025 онд Ерөнхийлөгчийн зарлигаар өндөр насны тэтгэвэрт гарсан болон өмнөх онуудад тэтгэвэрт гарч урамшуулал олгогдоогүй нийт шүүгчдэд хүндэтгэл үзүүлж, шүүгч тус бүрт



200,000 төгрөг буюу нийт 3,600,000 төгрөгийн мөнгөн урамшуулал, 684,000 төгрөгийн дурсгалын зүйл /холбооны лого бүхий үзэг/-ийг тухайн шүүгч болон салбар хороодын тэргүүн нарт олгосон байна. Уг журмын 2.3-т зааснаар гадаад улсад эмчилгээ хийлгэх шаардлагатай 1 шүүгчид 200.000 төгрөгийг 2.6-т зааснаар хүнд өвчний улмаас нас барсан 1 шүүгчийн ар гэрт 500.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.


- Төлөвлөгөөний 9.1-т Холбооны үйл ажиллагаатай холбоотой зарим журам батлах, \холбооны дүрмээр зохицуулах асуудлыг дүрэмд оруулах\

3.1 Бусад

Монголын шүүгчдийн холбооны тэргүүн Д.Батбаатар, Улсын дээд шүүхийн шүүгч, МШХ-ны гадаад харилцааны дэд хорооны ахлагч Ц.Цогт нар Салбар хороодын тэргүүн нартай цахим уулзалт хийж 2024 оны төлөвлөгөөний биелэлт, 2025 оны үйл ажилгааны төлөвлөгөөг танилцуулж харилцан санал солилцов.

“Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” төслийн хүрээнд хамтран ажиллах уулзалт боллоо

Канад Улсын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр тус Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхэлсэн Комиссарын газраас манай Улсын шүүх эрх мэдлийн салбарт “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” урт хугацааны төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбоотойгоор тус төслийн хүрээнд Монголын шүүгчдийн холбоотой хамтран ажиллах талаарх уулзалтыг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгууллаа.



Уулзалтад Холбооны тэргүүн, удирдах зөвлөлийн болон Шүүгчдийн ёс зүйн зөвлөх хорооны тэргүүн, гишүүд нөгөө талаас “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” урт хугацааны төслийг төлөөлж Канадын холбооны шүүхийн хэрэг эрхлэх газрын олон улсын хөтөлбөрийн хэлтсийн дарга Олег Шаков, Нью Брансвик мужийн шүүхийн Ерөнхий шүүгч Марк Ричард, хуульч, олон улсын хөгжлийн мэргэжилтэн Ян Моррисон болон бусад төслийн багийнхан оролцов.



Уулзалтаар Монголын шүүгчийн холбооны зүгээс хэрэгжүүлж байгаа, төслийн тавьсан зорилгод нийцэх ажлууд, Тухайлбал, Шүүхийн ёс зүйн зөвлөлдөх хорооны үйл ажиллагааг өргөжүүлж, бэхжүүлэх, гишүүдийг сургалтад хамруулах, Шүүхийн академи, Улсын Дээд шүүхийн Салбар хороотой хамтран хэрэгжүүлж буй “Judicial Wellbeing” сэдвээр сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг дэмжих, Олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгын хүрээнд шүүгч нараас олон нийтийн дунд явуулах яриа, таниулцуулгын жишиг гарын авлага боловсруулахад туслалцаа үзүүлэх,

-Монголын шүүгчдийн холбооны веб сайтыг шинэчлэн хөгжүүлэх,

-“Ярьж буй хууль” нэвтрүүлгийг үргэлжүүлэх,

-Хамтын ажиллагааны хүрээнд Канад улсад туршлага судлах,

-Шүүгчдийн холбооны чадвахийг бэхжүүлэх,

Шүүгчдийн зүгээс Нийт шүүгчийн хуралдаанаас сонгосон Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүдтэй харилцах арга механизмыг бий болгох боломжтой эсэх зэрэг асуудлуудаар санал солилцож, хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжтой гэж үзэн, хамтран ажиллах чиглэл, хүрээг нарийвчлан тодорхойлж төлөвлөгөө гаргах, төсөлд хамтран ажиллах байгууллагууд үйл ажиллагаагаа уялдуулах зэрэг шаардлагатай асуудлыг нарийвчлан тодорхой болгохоор тохиролцов.

Монголын шүүгчдийн холбооны дэргэдэх Ахмадын дэд хорооны гишүүд Чойжин ламын сүм музей үзэж танилцав.

Төлөвлөгөөт бус бусад ажлын хүрээнд

“Монголын шүүгчдийн холбоо”-ны Удирдах зөвлөлийн төлөөлөл Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүдтэй уулзалт хийлээ.

Шүүгчдийн холбооны Тэргүүн, Удирдах зөвлөлийн гишүүдээс Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шүүгч гишүүнээр сонгогдсон, Улсын дээд шүүхийн шүүгч П.Золзаяа, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Г.Даваадорж, Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч М.Мөнхдаваа, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч О.Жанчивнямбуу, Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.Өлзийжаргал нарт уулзалтын эхэнд баяр хүргэж, цаашдын ажилд нь амжилт хүсэв. Уулзалтаар шүүгчдийн эрүүл мэндэд онцгойлон анхаарч оношилгоо, шинжилгээг дотоод болон гадаадын эмнэлгүүдэд чанартай түвшинд хийлгэх ажлыг зохион байгуулахад шүүгчдийн оролцоог хангах, тодорхой түвшинд хамтран ажиллаж үр дүнд хүргэх, эрүүл мэндийн даатгалын гэрээ буцаан олголтын нөхцөл, хувь хэмжээг сайжруулах, шүүгч, ажилчдад бариулж

байгаа шүүхийн орон сууцны гэрээний нөхцөл, хүртээмжийн ажлыг зохион байгуулах, Шүүгчдийн холбооноос АНУ-ын ЭСЯ , Шихихутуг Их Сургуультай хамтарсан Фулбрайтын хөтөлбөртэй англи хэлний сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх, цахимжилттай холбоотой сургалтыг зохион байгуулах, ШЕЗ-ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал, харилцан мэдээлэл солилцох, гадаад харилцааг өргөжүүлэх, шүүх, шүүгч рүү чиглэсэн хууль бус үйлдэлд шуурхай, үр дүнтэй хамтран ажиллах талаар тус тус санал солилцлоо. Уулзалтын төгсгөлд талууд жил бүр хамтарсан уулзалтыг зохион байгуулж, байхаар тохиролцов.



Төлөвлөгөөний биелэлт

Шүүгчдийн холбооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 24 ажил тусгаснаас 18 ажил биелж, 6 ажил биелээгүй байна.



Биелээгүй төлөвлөгөө		
№	Төлөвлөгөө	Тайлбар
4.3	Шүүгчийг гадаад улсад мэргэжлийн болон эрдэм шинжилгээний ажил хийх, суралцах /сургалтын болон бусад тэтгэлэг дэмжлэгтэйгээр/ боломжийг нээсэн албан ёсны бодлогын баримт бичиг боловсруулж, холбогдох хууль, журамд тусгуулах	- Жилдээ
4.6	МХХ-той, харилцан тохиролцсоны дагуу “Санамж бичиг” байгуулах, Шүүгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын хэсэг байгуулах	Хамтран ажиллах талаар дэмжээгүй. МХХ-ны хорооноос 3 шүүгчийг “ярьж буй хууль” нэвтрүүлж нэвтрүүлгийн зардлыг төлөхөөр хамтран ажиллах тохиролцсон. Одоогоор төлбөр төлөгдөөгүй байгаа
4.9	АНУ Элчин Сайдын яамтай хамтран ажиллаж АНУ-ын төрийн департаментаас зохион байгуулдаг “АНУ-д төгсөгчдөө дэмжих” хөтөлбөрт хамрагдах, бичиж хүргүүлсэн төсөлд хариу авч, үргэлжлүүлэх /Ярьж буй хууль/	-
5.2	Орон нутгийн телевизүүдтэй гэрээ байгуулж “Ярьж буй хууль” нэвтрүүлгийг цацах талаар гэрээ байгуулах	Гэрээ байгуулаагүй.
7.1	Шүүгчдийн холбооны ахмад гишүүн шүүгчдийг Төрийн одон медаль, системийн бусад шагналд шагнуулах эсэхэд холбоо ямар оролцоотой байхыг судлах ажлын хэсэг байгуулах Шүүгчийн хүсэлтээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч, төлөөлөгч оролцуулахад туслалцаа үзүүлэх, шаардлагатай судалгаа, баримтуудыг гаргаж өгөх	-Тухай бүр

	байдлаар дэм өгөх, сэтгэл зүйн болоод бусад байдлаар дэмжих	
7.2	Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон Салбар хороод, гишүүдийг урамшуулах	-